

БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧ

Я.САРАНСҮХ

**МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ АУДИТЫН ХҮРЭЭНД
ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2022 оны 06 дугаар
сарын 21-ны өдөр

Дугаар
22-025

Улаанбаатар хот

АЖЛЫН ЗОРИЛГО

Хөндлөнгийн мэргэжлийн шинжээчээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитын хүрээнд Эрдэнэт ТӨҮГ-ын экспортод гаргаж буй зэс-молибдений баяжмалд агуулагдах дагалдах ашигт малтмалын нэр төрөл, агуулга, тоо хэмжээг тодорхойлж, дагалдах ашигт малтмалын үйлдвэрлэлийн үр ашгийг тооцох ажлыг гүйцэтгүүлэхэд энэхүү ажлын зорилго оршино.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

Шинжээч нь аудитын талбарын үе шатнаас эхлэн тайлагналын үе шат дуусах хүртэл хугацаанд хариуцсан асуудлаар аудитын багт мэргэжил, арга зүйн туслалцааг үзүүлж хамтран ажиллана.

Эхлэх хугацаа: 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр

Дуусах хугацаа: 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдөр

Байршил: Монгол Улс, Орхон аймаг, Уулын баяжуулах Эрдэнэт ТӨҮГ, Геологийн төв лаборатори, Гаалийн төв лаборатори

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Аудитын сэдэв батлах тухай” Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газрын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн “Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” аудитыг гүйцэтгэнэ.

Уг аудитад Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/82 дугаар тушаалаар баталсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-д заасны дагуу экспортод гаргаж буй ашигт малтмалд агуулагдаж буй дагалдах ашигт малтмалын нэр төрөл, агуулга, тоо хэмжээг тооцоход мэргэшсэн, ажлын туршлага бүхий шинжээчийг аудитад татан оролцуулах шаардлага үүссэн.

ХОЁР. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Шинжээч нь Эрдэнэт ТӨҮГ-ын экспортод гаргаж буй зэс-молибдений баяжмалд агуулагдах дагалдах ашигт малтмалын нэр төрөл, агуулга, тоо хэмжээг тодорхойлж, дагалдах

ашигт малтмалын үйлдвэрлэлийн үр ашгийг тооцоход Эрдэнэт ТӨҮГ, Гаалийн ерөнхий газар, Геологийн төв лабораторийн зарим үйл ажиллагааг бүрэн хамруулж дүгнэлт гаргана.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Шинжээч нь дараах ажил үүргийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

д/д	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Зорилго	Шалгуур үзүүлэлт
1	Холбогдох төрийн захиргааны байгууллагуудын хянаж, хүлээн авсан “Эрдэнэтийн овоо” зэс-молибдений ордын нөөцийн бүх тайлангуудад дүн шинжилгээ хийж, дагалдах ашигт малтмалын нэр төрлийг тодорхойлох	Нөөцийн тайланд тухайн ордод агуулагдаж буй ашигт малтмалын талаар дэлгэрэнгүй судалгаа хийсэн байна.	Нөөцийн тайланд тусгасан дагалдах ашигт малтмалыг тодорхойлох	Ашигт малтмалын тухай хуулийн 35.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглах үүрэг хүлээх бөгөөд зөвхөн ашиг олох зорилгоор түүнийг сорчлон ашиглахыг хориглоно Газрын хэвлийн тухай хуулийн 32.2 Ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, ордын зөвхөн баялаг хэсгийг нь сорчлон олборлохгүй байх
2	Гаалийн байгууллага болон Эрдэнэт ТӨҮГ-ын зүгээс үйлдвэрлэсэн баяжмалд хийж буй лабораторийн шинжилгээнд дүгнэлт өгөх, (үндсэн болон дагалдах элементийн талаар)	Лабораторийн шинжилгээ нь нөөцийн тайланд дурдсан дагалдах ашигт малтмал, түүний агуулгыг иж бүрэн тодорхойлж байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай байна.	Экспортод гаргаж буй баяжмалын агуулгад төрийн байгууллагуудын зүгээс тавьж буй хяналтын үр нөлөөг тодорхойлох	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журмын 2.3-т заасны дагуу “Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, Монгол Улсын итгэмжлэгдсэн лаборатори байх”
4	Үйлдвэрлэсэн баяжмалаас дээж авч хөндлөнгийн лабораторид шинжлүүлэх (дагалдах ашигт малтмалын нэр төрөл, агуулга)		Эрдэнэт ТӨҮГ-ын баяжмалд агуулагдаж буй дагалдах ашигт малтмалын нэр төрөл, агуулгыг тодорхойлох	Шинжилгээний арга баталгаажуулах журам, Лабораторийн шинжилгээнд сорьц хүлээн авах, боловсруулах, дээжийн хөдөлгөөний журам Эрдсийн түүхий эдийн ердийн тоон шинжилгээний чанарт гадаад хяналт хийх журам
5	Эрдэнэт ТӨҮГ-ын сүүлийн 10 жилийн байдлаар экспортолсон баяжмалд агуулагдах дагалдах ашигт малтмалын тоо хэмжээний талаар тойм тооцоо хийх	Экспортод гаргаж буй баяжмалд агуулагдах дагалдах ашигт малтмалд ногдуулах АМНАТ-ийн тооцооллыг хийх	Экспортолсон баяжмалд агуулагдах дагалдах ашигт малтмалын тоо хэмжээг тодорхойлох	Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
6	Баяжмалд агуулагдах дагалдах ашигт малтмалыг ялган авах боломж, эдийн засгийн үр ашиг, үнэ ханшийн талаар дүгнэлт гаргах		Дагалдах ашигт малтмалын эдийн засгийн үр ашгийн тооцоолол хийх	Засгийн газрын 2019 оны 465 дугаар тогтоолоор баталсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”

Нэмэлт шаардлага: Тухайн гүйцэтгэх ажил, үүргийн хүрээнд нэмэлт ажил хийх тохиолдолд гүйцэтгэх, ажил үүрэг бүрд нэмэлт ажил оруулах боломжтой.

7

Гүйцэтгэх нийт ажлын хүрээнд цаашид авах арга хэмжээ, засаж сайжруулах талаар тодорхой дүгнэлт гаргах.

ГЭРЭЭТ АЖИЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ХЭМЖЭЭ, ФОРМАТ

- Үе шатны ажлын тайлангууд нь хавсралтууд орохгүйгээр 15-аас багагүй, 35-аас ихгүй хуудас /мөр хоорондын зай "single" Arial үсгийн хэмжээ 12/ байх бөгөөд гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан, хавсралтуудтай байна.
- Дагалдах материал болон үнэлгээний тайлангийн эх бичвэрийн файлыг хавсаргана.
- Үе шатны болон нэгдсэн тайлан боловсруулахад ашигласан хууль тогтоомж, ном, хэвлэл, Олон Улсын Аудитын дээд байгууллагаас гаргасан тунхаглал, Аудитын дээд байгууллагуудын Олон Улсын стандарт мэдээлэл зэрэг эх үүсвэрийн жагсаалтыг хавсаргана.

ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Шинжээч нь ажлын даалгаварт тусгасан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, гэрээт ажлын зорилт үр нөлөөтэй байгаа эсэхийг хянан үзэж дүгнэлт гаргаж, үр дүнг гүйцэтгэх ажил, үүрэг тус бүрээр бүлэглэж тусгасан шинжээчийн тайланг бэлтгэнэ.

Шинжээчийн тайланд дүгнэлт гаргах явцад илэрсэн алдаа зөрчил, тэдгээрийн учир шалтгаан болон үр дагавар, эрсдэлд хийсэн дүн шинжилгээний үр дүнгээс гадна цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж, санал боловсруулж тусгана.

Шинжээчийн тайлан болон хавсралтаар гаргасан судалгаа, тооцоолол, бусад нотлох зүйлс, ажлын баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

ТАВ. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Ажлын даалгаварт заасан зорилго, зорилтын хүрээнд мэргэжлийн зөвлөгөө өгөх, дүгнэлт гаргах шинжээчийн баг нь уул уурхай, ашигт малтмалын салбар, олон улсын чиг хандлагын талаар өргөн мэдлэгтэй, зохих мэдээллийн сан бүрдүүлсэн, макро эдийн засаг, төсөв, санхүү, бизнес, гэрээ хэлцлийн талаар зохих мэдлэгтэй, судалгаа, шинжилгээ тооцоолол, дүгнэлт гаргах чадвартай иргэн, хуулийн этгээд байж болно.

Шинжээч, шинжээчийн баг нь дараах шаардлагыг хангасан мэдлэг, ур чадвартай ажилтантай байна. Үүнд:

- Геологич, геологи, уул уурхайн эдийн засагч мэргэжилтэй, магистр буюу түүнээс дээш зэрэгтэй;
- Салбартаа 10 буюу түүнээс дээш жил ажилласан, нөөцийн тайлан, олборлох болон баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах, минералог, минераграфийн шинжилгээ хийж байсан ажлын туршлагатай;
- Уул уурхайн салбарын мэргэшсэн эсвэл зөвлөх зэрэгтэй бол давуу тал болно.

Шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал

үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Бүрдүүлэх материал:

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, боловсролын зэргийн диплом, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бусад үнэмлэх сертификатын хуулбар;
- Ажлын туршлага тодорхойлсон дэлгэрэнгүй намтар /багийн гишүүн тус бүрээр/;
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугтуйлсан байх) ;

Энэхүү ажлын даалгаврын 5-д заасан шаардлагыг хангасан тухай нотлох баримтын баталгаажсан хуулбар ирүүлж, цуглуулсан бүх баримт, мэдээлэл, зөвлөмжийг хавсаргана.

ЗУРГАА. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ:

Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан санхүүжүүлэгч гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Гэрээт ажлын санхүүжилтийг гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу олгоно.

ДОЛОО. БУСАД

Дүгнэлт гаргах ажлыг гэрээгээр гүйцэтгэх шинжээч нь Үндэсний аудитын газрын Аудитын нэгдүгээр газрын аудитын баг бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллах бөгөөд шаардлагатай дэмжлэг, тусалцааг тус газраас үзүүлнэ.

Ажлын даалгаварт тусгасан ажлын гүйцэтгэгчээр шалгарсан шинжээч нь ажил эхлүүлэх, ажлын явцад үүсэх хүндрэл бэрхшээл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор захиалагч Үндэсний аудитын газар /Аудитын нэгдүгээр газар/-тай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч болно.

Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад илэрсэн зөрчил, шийдвэрлэх боломжгүй асуудал үүссэн тохиолдолд тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд шууд мэдэгдэнэ.

Хянасан:

АУДИТЫН НЭГДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ЭНХЖАВХЛАН

21/VI 2022.

АУДИТЫН УДИРДЛАГЫН МЕНЕЖЕР



Ж.БАТСАЙХАН

Боловсруулсан:

АХЛАХ АУДИТОР



Б.ХИШИГТОГТОХ